



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/11

Мөрөн сум

Инженерийн шугам сүлжээний ажлыг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил"-ын хүрээнд хийгдсэн 6 дугаар багийн Дулаан дамжуулах төв №11-ийн тоноглолын өргөтгөл, 6 дугаар багийн 8,9 дугаар гудамжны дулаан, цэвэр усны шугамын ажлыг хэсэгчлэн хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Та млын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Д.Аюушжав (Аймгийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Б.Аюуш (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)

Ч.Батсүх (Мөрөн сумын Засаг даргын орлогч)

П.Отгончимэг (Мөрөн сумын 6 дугаар багийн Засаг дарга)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Д.Хажидсүрэн ("Урбан девелопмент консалтинг" ХХК-ийн ахлах инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

С.Өнөрзаяа ("Санжат" ХХК-ийн инженер)
Н.Болор-Эрдэнэ ("Санжат" ХХК-ийн инженер)

6712010042

2.

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

П.Цэнгэнжаргал

(Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн инженер)

Д.Сүхээ

(Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн).

2. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

